



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 01118

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 4 дүгээр
цэцэрлэгийн балансаас
хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 4,800,000.0 /дөрвөн сая найман зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Чингэлтэй дүүргийн 224 дүгээр цэцэрлэгийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэг /А.Алтанзаяа/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Чингэлтэй дүүргийн 224 дүгээр цэцэрлэг /П.Эрдэнэчимэг/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэг /А.Алтанзаяа/-т, Чингэлтэй дүүргийн 224 дүгээр цэцэрлэг /П.Эрдэнэчимэг/-т тус тус үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2020 оны 04 дүгээр
сарын 06 өдрийн 0/... тоот тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1. Машин тоног төхөөрөмж										
1	Чингэлэг	20 тонн	2018	Ш	1	4,800,000	4,800,000	1,550,000	3,250,000	Чингэлтэй дүүргийн 224 дүгээр цэцэрлэг
Тоног төхөөрөмжийн дүн					1		4,800,000	1,550,000	3,250,000	